



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар

1715

Арвайхээр

Ус, рашаан ашиглуулах зөвшөөрөл  
олгох тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 01 дугаар ус, рашаан ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Хужирт суманд эмчилгээ, сувилгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Ананд Хужирт" ХХКомпани 2022 онд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах цэвэр усыг сумын төвийн худгаас 7457,0 м<sup>3</sup>/жил, 46° 54' 01,6" 102° 46' 24,6" цэгт байрлах рашааны худгаас 1800,0 м<sup>3</sup>/жил рашаан ашиглуулах зөвшөөрөл олгосугай.

2. Ус, рашаан ашиглуулах гэрээг тус газартай байгуулж, ус ашиглуулах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байхыг "Ананд Хужирт" ХХКомпаний гүйцэтгэх захирал (Ж.Баянтогтох)-д даалгасугай.

3. Усны тухай хууль болон холбогдох журам, стандартын хэрэгжилт, мөн ус, рашаан, шаврын ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.БАЯСГАЛАН

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ,  
ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог: Монгол	Эцэг (эх)-ийн нэр: Гэндэн	Нэр: Баясгалан
Албан тушаал: Газрын дарга	Ажиллаж байгаа байгууллага: Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: 2021.02.16 6/05	Байгууллагын хаяг: Нутгийн удирдлагын ордон 502 тоот	
Албан үүргийн төрөл: Тушаал	Тайлбар: Ус, рашаан ашиглуулах зөвшөөрөл олгох тухай	

Сонирхлын зөрчилтэй эсэх Тийм ☐ Үгүй ☒

Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан Гэндэнгийн Баясгалан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:


- ☐ гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:
- ☐ гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:
- ☐ байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:
- ☐ Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

Дөрөв. Баталгаажуулалт.

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

Дарга  
/албан тушаал/

  
/гарын үсэг/

/Г.Баясгалан/  
/нэр/

2022 он 04 сар 12 өдөр  
6210274139-9129944

Шийдвэрлэсэн байдал

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх

Тийм ☐ Үгүй ☐

Хэрэв "Тийм" бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

- ☐ Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй
- ☐ Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй
- ☐ Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

..... /албан тушаал/ ..... /гарын үсэг/ ..... /нэр/

..... он ..... сар ..... өдөр